



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/298

Булган сум

**Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхэд
шаардагдах хөрөнгийг гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоолын 05 дугаар хавсралтын 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Автотээврийн хэрэгслийн ашиглахыг хориглосон эвдрэл гэмтэл, техникийн зөрчил, задрах боломжгүй овор хэмжээ, даац хэтрэлттэй ачаа тээврийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Баяннуур, Хутаг-Өндөр сумын Төлбөр авах цэг дээр ажиллах ажлын хэсгийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх хяналт шалгалтад шаардагдах зардлыг аймгийн Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан “Хөндлөнгийн хяналт тавих” зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн төсвийн Ерөнхий нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010400

Аймгийн Засаг даргын 2026 оны
 04 дүгээр сарын 20-ны/ний өдрийн
 А.Д.92 дугаар захирамжийн хавсралт



Автотээврийн хэрэгслийн ашиглахыг хориглосон эвдрэл гэмтэл, техникийн зөрчил, задрах боломжгүй овор хэмжээ, даац хэтрэлттэй ачаа тээврийн хяналт шалгалтын ажлын хэсгийн зардлын тооцоо

Д/д	Явах чиглэл	Явах замын хэмжээ /км/	Хугацаа (ажиллах)
1	2	3	4
1	Булган-Баяннуур	190	5
2	Баяннуур сум дотор	120	
3	Баяннуур-Булган	190	
4	Булган-Хутаг-Өндөр	150	5
5	Хутаг-Өндөр дотор	100	
6	Хутаг-Өндөр-Булган	150	
	Дүн	900	10

Д/д	Шаардлагатай зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үнэ (төгрөг)	
				Нэг бүр	Нийт
1	2	3	4	5	6
1	Шатахуун	Км/л	1 машин 900 км нийт 135 литр түлш	4330	584,550
2	Томилолт	өдөр	1 хүн 10 өдөр	90,000	900,000
	Дүн				1,484,550

--o00o--